

“ХАР ХОРУМ ПРОПЕРТИЙС” ХК

2019 оны 12 дугаар сарын 14-ний өдөр

ТУЗТ 03/2019

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Компанийн хувьцаа эзэмшигчдийн
ээлжит бус хурал зарлан
хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.2, 76.1.3, 60 дугаар зүйлийн 60.2, 60.3, 60.4, 61 дүгээр зүйлийн 61.1.2, 61.1.3, 61.1.4, 61.1.5 дахь заалт, Компанийн дүрмийн 10.10.10, 10.10.11, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 12.00 цагт Улаанбаатар хот, Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хороо, Энхтайваны өргөн чөлөө 7/2, Денвер оффис, 401 тоот, Эрдэнэс Сольюшинс ХХК-ийн байранд зарлан хуралдуулсугай.
2. Энэ тогтоолын 1-т заасан хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудлуудыг 1 дүгээр хавсралтаар, хурлын хөтөлбөр, дэгийг 2 дугаар хавсралтаар, хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын танилцаж болох баримт материалын жагсаалтыг 3 дугаар хавсралтаар, хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудал бүрийн санал авах “Санал авах хуудас”-ыг 4,5 дугаар хавсралтаар, хувьцаа эзэмшигчдэд хүргэх хурлын зарын загварыг 6 дугаар хавсралтаар, хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төслийг 7-р хавсралтаар тус тус баталсугай.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2020 оны 01 дүгээр сарын 05-ний өдрөөр тасалбар болгон тогтоосугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын зар, мэдээг 2019 оны 12 дугаар сарын 19-ны өдрөөр дахин зарлах өдрийг 15 өдрийн дараа байхаар тогтоож, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 377 дугаар тогтоолоор баталсаны дагуу “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх тухай” журамд заасан хэлбэр, шаардлагын дагуу хувьцаа эзэмшигчдэд хүргэх ажлыг зохион байгуулахыг хурал зохион байгуулах комисс /Э.Сод-Эрдэнэ/-д даалгасугай.
5. Хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд энэхүү шийдвэрийн 1 дүгээр хавсралтад заасан бичиг баримттай 2019 оны 12 дугаар сарын 16-ны өдрөөс 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 17.00 цаг хүртэл ажлын өдрүүдэд ажлын 9-17 цагийн хооронд Улаанбаатар хот, Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хороо, Энхтайваны өргөн чөлөө, 7/2, Денвер оффисын, 4-р давхарт “Эрдэнэс сольюшинс” ХХК-ийн байранд танилцуулах ажлыг зохион байгуулахыг хурал зохион байгуулах комисс / Э.Сод-Эрдэнэ /-д даалгасугай.

6. Хувьцаа эзэмшигчдээс “Санал авах хуудас”-ыг хүлээн авах сүүлийн өдрийг харьяалагдах брокерийн компаниар дамжуулан авч байгаа тохиолдолд уг саналын хуудсыг 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 16 цагаас өмнө байхаар тогтоосугай.
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зохион байгуулах комиссыг 2 хүний бүрэлдхүүнтэйгээр байгуулсугай.
8. Хурал зохион байгуулах комиссын
 - a. Даргаар: Э. Сод-Эрдэнэ
 - b. Гишүүн: Э. Шагдарсүрэнтооллогын комиссын
 - c. Даргаар: Э. Шагдарсүрэн
 - d. Гишүүнээр: Э. Сод-Эрдэнэ нарыг тус тус томилсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



/Б.БАТХҮҮ/

“Хар хорум пропертийс” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн ТУЗТ 03/2019 тоот тогтоолын 1 дүгээр хавсралт

**“ХАР ХОРУМ ПРОПЕРТИЙС” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
БУС ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН
ЖАГСААЛТ**



1. Компанийн үйл ажиллагааны байдлаарх тайлан;
2. Эрдэнэс сольюшинс ХХК-иас ирүүлсэн Хар хорум пропертийс ХК-ны 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 1 ширхэг энгийн хувьцаанд Эрдэнэс сольюшинс ХХК-ийн 1 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 100 ширхэг энгийн хувьцааг тэнцүүлж, Компанийг нэгтгэх замаар өөрчлөн байгуулах төсөл, Нэгтгэх гэрээний төслийг хэлэлцэж, батлах тухай;
3. Хар хорум пропертийс ХК-д Эрдэнэс сольюшинс ХХК-ийг нэгтгэх талуудын 2019 оны 12-р сарын 31-ны байдлаар хөндлөнгийн аудит хийгдсэн санхүүгийн тайлан, хөрөнгийн үнэлгээний тайлан, хуулийн дүгнэлтийг хэлэлцэж, батлах тухай;
4. Хар хорум пропертийс ХК-д Эрдэнэс сольюшинс ХХК-ийг нэгтгэхтэй холбогдуулан Хар хорум пропертийс ХК-ний зарласан энгийн хувьцаанаас хаалттай хүрээнд 1 ширхэг нь 100 /нэг зуу/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй 1'700'000'000 /нэг тэрбум долоон зуун сая/ ширхэг хүртэлх энгийн хувьцааг нэмж эргэлтэд гаргах тухай;
5. Хар хорум пропертийс ХК-д Эрдэнэс сольюшинс ХХК-ийг нэгтгэхтэй холбогдуулан хаалттай хүрээнд нэмж гаргах хувьцаанаас тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байх тухай;
6. Хар хорум пропертийс ХК-д Эрдэнэс сольюшинс ХХК-ийг нэгтгэхтэй холбогдуулан хувьцаа эзэмшигч өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авах шаардах эрх үүссэн тухай;
7. Хар хорум пропертийс ХК-ийн үйл ажиллагааны чиглэлд нэмэлт оруулах тухай;
8. Хар хорум пропертийс ХК-ийн оршин байх хаягийг өөрчлөх тухай;
9. Хар хорум пропертийс ХК-ийн оноосон нэрийг нэгтгэж буй Эрдэнэс сольюшинс ХХК-ийн оноосон нэрээр солих тухай;
10. Хар хорум пропертийс ХК-ийн Дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг батлах тухай;
11. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг шинээр томилох тухай.